

АРДЧИЛЛЫН ҮНДЭС ХӨТӨЛБӨР

Ардчиллын Үндэс хөтөлбөр нь шударга ёс, үүрэг хариуцлага, эрх мэдэл, хувийн эрх чөлөө гэсэн ардчиллын суурь үнэт зүйлсийг сурагчдад эзэмшүүлснээр тэднийг чадвартай, мэдлэгтэй, хариуцлагатай, бүтээлч иргэн хүн болгон төлөвшүүлэх зорилготой юм. Бидний үүрэг бол сурагчдад өөрсдийн ухаалаг сонголтыг хийх чадварыг хөгжүүлэхэд нь туслах юм. Юу хийх ёстойгоо бодохоос илүүтэй хэрхэн бодож тунгаах чадварыг хөгжүүлэх нь чухал. Ийм зарчмаар суралцах нь ардчилсан нийгмийг хамгаалах ба сайжруулан хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай зарчим, явц, үнэт зүйлсэд ухаалаг, зохистой хандах хандлагыг төлөвшүүлж чадна.

Энэхүү хөтөлбөр нь

- 👍 Үндсэн хуульт ардчилсан нийгмийн байгуулал болон ардчиллын суурь зарчим, үнэт зүйлсийг ойлгуулах
- 👍 Хүүхэд залуучуудын идэвхитэй, хаируцлагатай иргэн болоход зайлшгүй шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх
- 👍 Хувийн болоод нийгмийн амьдралд шийдвэр гаргах, асуудал, зөрчлийг зохицуулахдаа ардчилсан арга замыг хэрэглэх ойлголт, хүсэлтэй болгоход чиглэсэн болно.

Ардчиллын Үндэс Цуврал нь

1. “Төгөлдөр үүрэг хариуцлагад суралцсан нь”, “Бамбаруушнууд шударга ёсонд суралцсан нь”, “Алтайхай эрх чөлөө нөхөрлөлд суралцсан нь”, “Дарам Дэрэм хоёр эрх мэдэлд суралцсан нь” нэр бүхий сургуулийн бага ангийн 1- 3 дугаар ангийн хүүхдэд зориулсан дөрвөн цуврал зурагт уншлагын ном.
2. “Төгөлдөр үүрэг хариуцлагад суралцсан нь”, “Бамбаруушнууд шударга ёсонд суралцсан нь”, “Алтайхай эрх чөлөө нөхөрлөлд суралцсан нь”, “Дарам Дэрэм хоёр эрх мэдэлд суралцсан нь” гэсэн дөрвөн цуврал номын багшийн гарын авлагаас бүрдэнэ. Гарын авлага нь 4-6 хичээлийг хэрхэн заах аргачлал, санаа, дасгал ажлууд, дүрд тоглох, асуулт хариулт, дүгнэлт дасгалууд болон сурагчдын ойлголтыг үнэлэх дасгалыг багтаасан болно.
3. Сургуулиас гадуур эцэг эх ч хүүхдүүдтэйгээ хамт уншиж судалж болно. Гэхдээ дээр дурдсан үнэт зүйлсийг хандлага болгох гэдэг зарчмыг мартаж болохгүй.

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

ТӨГӨЛДӨР ҮҮРЭГ ХАРИУЦЛАГАД СУРАЛЦСАН НЬ

Үүрэг хариуцлагын зарчмыг танилцуулах нь

Үүрэг хариуцлага хэмээх ойлголт нь зөвхөн ардчиллын үнэт зүйл төдийгүй нийгэмд, иргэн бүрийн өдөр тутмын амьдралд зайлшгүй байх ёстой хандлага юм. Хэрвээ хувь хүн үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй бол тэр нь нийгэмд шууд нөлөөлдөг.

Үүрэг хариуцлага гэдэг нь нийгмийн доторхи уялдаа холбоог дэмжигч гол түлхүүр билээ. Үүрэг хариуцлагагүй нийгэмд хувийн ашиг сонирхол давамгайлсан, туйлширсан нөхцөл байдал бий болдог.

Нөгөө талаас хувь хүний үүрэг хариуцлагыг авч бусдад хүлээлгэх юм бол энгийн иргэд өөрсдийн амьдралыг хянаж чадахгүй, эсвэл хянах боломжгүй байхыг хүлээн зөвшөөрсөн хэрэг болно. Хувь хүний үүрэг хариуцлага хүлээх эрх чөлөө буюу боломжыг багасгах юм бол эрх чөлөө хөгжин цэцэглэх боломжгүй юм.

Энэ хичээлийн хөтөлбөр нь хүүхдүүдэд хувийн болон нийгмийн амьдралд үүрэг хариуцлагын чухал болохыг мэдүүлэхэд чиглэсэн билээ. Бидний зорилго бол тэдний үүрэг хариуцлагатай холбоотой асуудлыг ухаалаг үр бүтээлч шийдэх чадвар, хүсэл сонирхлыг урамшуулан дэмжих болно.

АГУУЛГА

1) Нэгдүгээр бүлэг - Үүрэг хариуцлага гэж юу вэ?

Үүрэг хариуцлагыг тодорхойлох - хүнд хийж гүйцэтгэх ёстой, эсвэл хийхгүй ёстой үүрэг гэж зүйл байдаг гэдэг ойлголтыг өгнө.

2) Хоёрдугаар бүлэг- Үүрэг хариуцлага хүлээх эсэхээ хэрхэн шийдэх вэ?

Үүрэг хариуцлага хүлээх нь үр дагавар авчирдаг. Тиймээс түүнээс гарах ашигтай болон ашиггүй үр дагаврыг харгалзан үзэж байж шийдвэр гаргахад суралцана.

3) Гуравдугаар бүлэг -Олон үүрэг хариуцлагаас чухлыг нь хэрхэн сонгох вэ?

Зарим тохиолдолд хүмүүст нэгэн зэрэг хэд хэдэн үүрэг хариуцлага хүлээх шаардлага гардаг. Энэ үед хэрхэн шийдвэр гаргах вэ? Үүрэг хариуцлага хүлээх нь заримдаа хувийн ашиг сонирхол, үнэт зүйлстэй зөрчилдөх нь бий гэдгийг сурч мэднэ.

4) Дөрөвдүгээр бүлэг- Хэн үүрэг хариуцлага хүлээх ёстойг хэрхэн мэдэх вэ?

Тодорхой тохиолдолд хэн үүрэг хариуцлага хүлээх ёстойг, яагаад чухал болохыг хүүхдүүд мэдэж авна. Ингэснээр буруу болон бусдад хор хохирол учруулсан үйлдэл хийсэн хүмүүст шийтгэл оногдуулах эсвэл сайн зүйл хийсэн хүнийг урамшуулах боломжтой болно.

5) ҮНЭЛГЭЭНИЙ ДАСГАЛ АЖИЛ

*НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?*

Хичээлийн үндсэн ойлголт:

Үүрэг хариуцлага гэдэг нь хийх ёстой зүйлээ үйлдэх, хийх ёсгүй зүйлийг эс үйлдэхийг хэлнэ. Түүнчлэн үүрэг хариуцлага гэдэг нь амлалт, ажил, гэр бүл, дүрэм журам гээд олон эх сурвалжаас үүсдэг. Хичээл дээр хийх дасгал ажлуудаас үүрэг хариуцлагыг сайн биелүүлэх эсвэл биелүүлэхгүй байвал юу тохиолдож болох талаар суралцана.

Хүлээгдэх үр дүн:

- *Үүрэг хариуцлага хэмээх нэр томъёог тодорхойлох*
- *Жишээн дотроос үүрэг хариуцлагыг ялгах*
- *Үүрэг хариуцлагыг биелүүлэх ба эс биелүүлэхээс үүсэх шагнал урамшуулал, шийтгэлийг тодорхойлох чадвартай болно.*

Хичээлийн бэлтгэл ба шаардалагтай материал:

- “Төгөлдөр үүрэг хариуцлагад суралцсан нь” ном, Нэгдүгээр бүлэг, Хуудас 2-19
- Зургийн цаас, өнгийн харандаа
- Гарын авлагын арын хуудсанд байгаа өнгөөр будах дүрийн маскууд

Тайлбарлан ойлгуулах санаанууд:

Хүүхдүүдэд энгийн үгээр үүрэг хариуцлага гэдэг нь хүмүүсийн хийх ёстой шаардлагатай зүйлээ хийх, хийх ёсгүй зүйлийг хийхгүй байхыг хэлнэ гэдгийг ойлгуулна. Тэднээс хүмүүс өөрсдийн үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй бол юу тохиолдож болох талаар асуун ярилцаж үүрэг хариуцлагын чухлыг ойлгуулах хэрэгтэй.

Үүрэг хариуцлагаа биелүүлсэн хүнд олон төрлийн шагнал урамшуулал оногдоно гэдгийг хэлж өгнө. Өөрөөрөө бахархах, өөртэй итгэлтэй байх, бусдаас магтаал урамшуулал хүртэх, шагнал урамшуулал хүртэх гэх мэт. Үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй бол өөрөөсөө ичих, бусдаас санаа зовох, гэм буруутайдаа гэмших, бусад хүмүүсээс зэмлэл хүртэх, шийтгэл, торгууль хүлээх, давуу тал, хөнгөлөлтөө алдах гэх мэт олон зүйлд хүргэж болно гэдгийг тайлбарлан ярилцана.

